

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2025 оны 2 дугаар улирлын байдлаар)

2025 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын “Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг тухай бүрт www.erp.ulaanbaatar.mn программд, хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллалаа.

2025 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 26 өргөдөл хүсэлт ирснийг программд бүртгэн, 23 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 3 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. 11-11 төвөөс ирсэн 1 өргөдөл ирснийг холбогдох албан хаагчдад шилжүүлэн судалж байна. Үүнд:

1. Хүсэлт-26

- ✓ Байгууллагын албан хаагчид-15
- ✓ Иргэд-11

2. Гомдол-1

- ✓ Байгууллагын албан хаагчид-0
- ✓ Иргэд-1 ирсэн байна.

Хүснэгт-1 Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа


Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл, гомдол
	3	10	39	24

**2025 ОНЫ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ
ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд манай байгууллагад ирсэн нийт 27 өргөдөл, гомдлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-д бүртгэсэн байна.

Өнгөрөгч 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 30 өргөдөл, гомдол хүлээн авч хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн байна. 2024-2025 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 2 дугаар улирлын дараах графикаар харьцуулсан. (График-1)

График-1



2025 оны 2 дугаар улирлын байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг (диаграмм-2) Захиргаа хүний нөөцийн хэлтэс 23, Санхүү, төлөвлөлтийн хэлтэс 4, байгууллагын хэмжээнд нийт 27 өргөдөл гомдлоос журмын дагуу хуулийн үндэслэлтэй 23 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна.

(Диаграмм 2)



(2025 оны 2 дугаар улирлын байдлаар)

2025 оны 2 дугаар улирлын байдлаар хандалтаараа тэргүүлж байгаа 3 асуудал нь ажилд орох хүсэлт 10 (37,04%), ажлаас чөлөөлөгдөх тухай 7 (25,93%) цалин, хөлсний тухай 4 (14,81%), ирсэн байна.

Өргөдөл, гомдлын программд нийт 27 өргөдлийг бүртгэж, 23 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 19 (82,61%), 10 хоногт 3 (13,04%), 30 хоногт 1 (4,35%).

2025 оны 2 дугаар улирлын байдлаар хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0,87 буюу "B" үнэлгээтэй байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



Байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл гомдлын нэгдсэн системд бүртгэж, удирдлагад өдөрт багтаан шилжүүлж, удирдлагын цохолттой ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөр нь хүлээн авч танилцан, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хийж ажилласан. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар өдөрт нь багтаан аваагүй зөрчил 23, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил 1, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Өргөдөл гомдлын зөрчлийг өмнөх онтой харьцуулахад 24 нэгжээр өссөн дүнтэй байна.